

Хэсэг 2

Монгол улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн өнөөгийн байдал, цаашдын хандлага

Чулуундоржийн Хашчулуун

Редакторын тайлбар: Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга Ч.Хашчулуун Монголын нэг талдаа асар том өсөн дэвжиж буй хийгээд нөгөө талдаа тэгш бус эдийн засгийн хөгжлийн хандлагын талаар өөрийн санал бодлоо хуваалцсан юм. Монголын алс орон нутгуудад өрнөж буй уул уурхайн томоохон төслүүдээс олох ашиг нь ойрын жилүүдэд Монголын эдийн засгийг жилд дунджаар 20 хувиар өсгөнө гэсэн тооцоо байдаг. Хөдөөгийн малчид, иргэдийн үзэл бодол хийгээд хот суурин, нийслэл дэх эдийн засгийн нөлөөг харгалзан үзвэл энэ хөгжил хол биш болжээ. Тэрээр эдийн засгийн өсөлт, нийгмийн хөгжлийн нарийн тооцоо бүхий, төсөв санхүүгийн хувьд хариуцлагатай төлөвлөгөөг Монголын Засгийн газар боловсруулсан хийгээд энэхүү төлөвлөгөө нь уул уурхай, дэд бүтцийн хөгжлийг дэмжихийн сацуу эдийн засгийн бүтцийг төрөлжүүлж, хүмүүн баялгийг нэмэгдүүлж, төр-хувийн хэвшлийн түншлэлийг гүнзгийрүүлэхэд чиглэнэ гэдгийг илтгэлдээ тэмдэглэсэн байна.

Мөн тэрээр Монголын эдийн засаг эрчимтэй өсч буй ч ядуурлын түвшин огт буурахгүй, өндөр байгааг тэмдэглэв. Өсөн нэмэгдэж байгаа баячууд болон хөдөөгийн малчид, нийслэл, төв суурин газарт улам бүр олиширч буй ядуу иргэдийн хоорондох баялгийн тэгш бус хуваарилалтын асуудал энэ хурлын үеэр хэлэлцэгдсэн нийгэм, улс төр, эдийн засгийн гол зангилаа асуудал байсан юм. Гадаадаас орж ирж буй их хэмжээний мөнгө, Засгийн газрын зардлаас үүдэлтэйгээр баялгийн хуваарилалт, Монголчуудын нийгмийн хамгаалал, Монголын үндэсний болон нийгмийн хөгжлийн гол зорилго, үнэ цэнэ юу болох тухай асуудал ч урган гарч байгаа юм.

Ч.Хашчулуун эдгээр асуудлыг тал бүрээс нь нухацтай ажиглаж, хури, хүчтэй хөндөн гаргасан нь анхаарал татаж байна. Тэрээр энэхүү хуралдаан, хэлэлцүүлэгт маш идэвхтэй оролцсон юм.

Монгол улсын хөгжлийн өнөөгийн түвшин

Дэлхий нийтийг хамарсан санхүү, эдийн засгийн хямралын хүндрэл, бэрхшээл ард хоцорч 2010 онд дэлхийн ихэнхи улс, оронд эдийн засгийн өсөлт ажиглагдсан. Манай улсын хувьд Олон улсын валютын сантай хамтран “Стэнд бай” буюу тогворжуулалтын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсний үр дүнд эдийн засагт сэргэлт гарч дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий бодит хэмжээ 2010 онд урьдчилсан гүйцэтгэлээр 6 хувиар өсч чадлаа. Өнгөрсөн онд инфляцийн түвшин хүнсний гол нэр төрлийн барааны өсөлтөөс шалтгаалан өндөр байсан бол 2011 онд инфляцийн түвшин тогтвортой байх төлөвтэй байна.

Дэлхийн банкны орлогын ангиллаар Монгол Улс нь бага-дунд орлоготой орны ангилалд багтаж, Монгол Улс нь 2007 онд хүний хөгжлийн индексээр дэлхийн 182 орноос 115 дугаарт буюу 67 орны өмнө жагсаж байсан бол 2010 оны байдлаар дэлхийн 169 орноос 100 дугаар байрт буюу 69 орны өмнө жагсаж, хүний хөгжлөөрөө дунд зэргийн гэсэн ангилалд хамаарагдаж байна. Өнгөрсөн онд инфляцийн түвшин хүнсний гол нэр төрлийн барааны өсөлтөөс шалтгаалан өндөр байсан бол 2011 онд инфляцийн түвшин тогтвортой байх төлөвтэй байна. 2011 оны урьдчилсан байдлаар манай улсын өрсөлдөх чадварын үзүүлэлт, бизнесийн орчины олон улсын үзүүлэлтүүд сайжирсан нь судалгаагаар гарахаар байна.

2010 онд манай улсын экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээл дээр өндөр байсантай холбоотойгоор ДНБ-ий хэмжээ мөн өсөж, нэг хүнд ногдох

ДНБ-ий хэмжээ 2,221.5 ам.долларт хүрсэн. Энэхүү өсөлт хөгжлийг цаашид тууштай үргэлжлүүлж ажиллах зорилгын хүрээнд манай улс газар тариалан болон мал аж ахуйн салбараа хөгжүүлэхээр “Монгол Мал”, “Атрын 3 дахь аян” зэрэг үндэсний хөтөлбөрүүдийг Улсын Их Хурлаас батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд цаашид энэ салбарын хөгжил эрчимжих үндсийг тавьж өгөх юм. Мөн “Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр”-ийн төлөвлөгөөнд тусгагдсанаар нийслэл болон хөдөө орон нутагт мах, сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон арьс шир, ноос ноолуур боловсруулах үйлдвэрүүд шинээр ашиглалтад орохоор байгаа нь боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхээр байна.

Хэдийгээр эдийн засаг хурдтай өсч, ядуурлыг бууруулах чиглэлээр олон арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа боловч ядуурлын түвшин дорвитой буурч чадахгүй байна. Ядуурлын түвшин 2009 онд 38.7 хувь байсан бол 2010 оны байдлаар 39.2 хувьд хүрээд байна. Монгол Улсын МХЗ-уудад суурилсан ҮХЦБ (2007-2015), Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын үндсэн баримт бичгүүдэд ядуурлыг бууруулах, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх асуудлыг гол зорилгоо болгож, энэ чиглэлийн арга хэмжээг бүрэн дэмжин ажиллаж байна.

Засгийн газраас 2011 оныг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил” болгон зарлаж, энэ хүрээнд хөдөлмөр зуучлалын үйл ажиллагааг сайжруулах, иргэдийн мэргэжил олгох, давтан сургах тогтолцоог сайжруулах, ажлын байран дээрх сургалтыг дэмжих, нэмэгдүүлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж байна. Эдийн засгийн өндөр өсөлт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын үр дүнд ажилгүйдлийн түвшин 2010 оны 12 сард 13 хувь байснаа энэ оны 6 дугаар сар гэхэд 8.7 хувь болтол буурсан байна.

Монгол Улсын нэг өрхийн сарын дундаж нийт орлого 2007 онд 263.7 мянган төгрөг, 2008 онд 363.6 мянган төгрөг,

2009 онд 402.5 мянган төгрөг, 2010 онд 479.2 мянган төгрөгт хүрч, жилд дунджаар 26.8 хувиар өсчээ.

Манай улс уул уурхайн том төслүүдээ эдийн засгийн эргэлтэнд оруулах, түүнтэй холбогдох санхүү, дэд бүтцийг бий болгох стратеги баримтлан ажиллаж байна. Байгалийн баялгийн арвин нөөцтэй ихэнхи улс орон баялгаа үр ашигтай зарцуулсан байхад зарим нэг нь буруу бодлого хэрэгжүүлж, хөгжлийн үнэт боломжоо алдсан гашуун туршлагауд байдгийг бид судлан, төрийн бодлого хөтөлбөрөө хэрэгжүүлж байна. Стратегийн томоохон орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулж, түүхий эдийг гадаад зах зээлд нийлүүлэх, тээвэрлэх болон олон улсын зах зээлд гаргахын тулд биднээс ихээхэн хүчин чармайлт гаргах шаардага тулгарч байна.

Энэхүү бодлогын чиглэл нь манай улс зөвхөн түүхий эд нийлүүлэгч орон болох, эсвэл аливаа нэг орны эдийн засгаас шууд хамааралтай болох бус, харин эдгээр байдлаас сэргийлэхэд оршиж байгаа болно. Эдийн засгийг хөгжүүлэх олон талт бодлогын хүрээнд экспортын барааны нэр төрлийг олшруулж, нэмүү өртөг шингэсэн бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих нь чухал юм. Уул уурхайн салбарын хөгжил дээр тулгуурлан Монгол Улс аж үйлдвэр хөгжсөн орон болохын төлөө бид зорин ажиллаж байна.

Энэ ч утгаараа манай улс хөгжлийн шинэ шатанд гараад байгаа бөгөөд орчин үеийн шинэ аж үйлдвэрийн цогцолборыг Сайншанд хотод барих, ижил төстэй төвүүдийг бусад бүс нутагт байгуулах, дэд бүтцийн салбарыг шинэчлэх, шинээр төмөр зам, автозам барихын зэрэгцээ хамгийн сүүлийн харилцаа холбооны технологийг нэвтрүүлэх зорилготой ажиллаж байна. Оюутолгой, Тавантолгой, Ухаа худаг зэрэг уул уурхайн төслүүдийн барилга, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлаас гадна, “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эхлэх, мянганы замын босоо, хэвтээ тэнхлэгийн барилгын ажил, нийслэл хотын автозамыг

сэргээн засварлах, 100 мянган айлын орон сууц төсөл зэрэг дэд бүтцийн бүтээн байгуулалтын томоохон ажлууд хийгдэхээр төлөвлөж байна. Эдгээр зорилтуудын түрүүчээс аль хэдийн өнөөдөр биеллээ олоод байгаа билээ.

Дээрхээс харахад манай улсын хөгжлийн гараанд ирээд буй энэ чухал үед гадаад нөхцөл байдлыг таатай бүрдүүлэх нь эдийн засгийн хөгжил, цэцэглэлтэд голлох байр суурь эзлэх нь харагдаж байна. Манай улсын уул уурхай болон бусад салбарт дэлхийн олон улс орны үндэстэн дамнасан том пүүс корпорацууд анхаарлаа хандуулаад байгаа нь манай хөгжлийн нэг томоохон хүчин зүйл болж байгаа.

Макро эдийн засаг

Дэлхийн эдийн засгийн 2008-2009 оны хямралын дараагаар Монгол Улсын эдийн засагт гадаад нэн тааламжтай орчин бүрдэсний зэрэгцээ бизнесийн орчныг сайжруулж, томоохон төслүүдийг эхлүүлэх шийдвэр гарч, хүн амын дотоод эрэлтийг нэмэгдүүлэх зэрэг бодлого баримталснаар гадаадын шууд хөрөнгө оруулалт болон экспорт хурдтай дээшилж эдийн засаг богино хугацаанд маш хурдтай өслөө. Монгол Улсын эдийн засаг 2010 оны эхний хагас жилд 7 хувиар өсч байсан бол 2011 онд 14.3 хувиар өссөн нь бүс нутагтаа төдийгүй дэлхийд өндөр өсөлт байлаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн зардлын хэмжээ 2011 оны эхний хагас жилийн байдлаар 32 хувиар өссөн нь нэлээд өндөр тоо боловч нэрлэсэн ДНБ-д 40 хувийг эзэлж байна.

Мөн эдийн засгийн өсөлтийг дагаад улсын нэгдсэн төсвийн орлого оны эхний 8 сарын байдлаар өмнөх оноос бараг 60 хувиар өсч, төсвийн тэнцэл 226 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

Эрдэс бүтээгдэхүүний экспорт эхний 8 сарын байдлаар 80 орчим хувиар өсч, экспортын орлогын нийтдээ 2.9

тэрбум ам.долларт хүрсэн бол хөрөнгө оруулалт, барилга угсралтын ажлын идэвхижил, газрын тосны бүтээгдэхүүний үнэ болон тоо хэмжээний өсөлтөөс шалтгаалан импорт 4.2 тэрбум ам.долларт хүрснээр гадаад худалдааны тэнцэл 1.3 тэрбум ам.долларын алдагдалтай гараад байна. Хэдийгээр гадаад худалдааны алдагдлын хэмжээ өндөр байгаа боловч нийт төлбөрийн тэнцэл эхний 7 сарын байдлаар 288 сая ам.долларын ашигтай байгаа нь гадаад секторын тэнцэл эерэг байгааг илгэж байна.

Эхний долоон сарын байдлаар гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 2.2 тэрбум ам.долларт хүрсэнээр төлбөрийн тэнцэл эерэг гарав.

Нэрлэсэн ДНБ-ий өсөлтөөс шалтгаалан мөнгөний нийлүүлэлт өмнөх оны мөн үеэс 61.7 хувиар өсөөд байна.

2011-2013 онд эдийн засгийн бүтцийн чиг хандлагыг авч үзвэл Оюутолгой, Тавантолгой болон бусад стратегийн томоохон орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулж байгаатай холбоотой ДНБ-д эзлэх уул уурхайн салбарын хувь хэмжээ нэмэгдэхээр байна. Тухайлбал, 2013 онд Оюутолгой орд газарт баяжуулах үйлдвэр ашиглалтад орсноор зэсийн баяжмалын олборлолтын хэмжээ одоогийн түвшингээс 3 дахин нэмэгдэнэ. Түүнчлэн 2012-2013 онд Тавантолгойн орд газраас олборлох нүүрсний хэмжээ өсч, жилд 15 орчим сая тонн нүүрс олборлож экспортлох хэмжээнд хүрнэ гэж тооцоолж байна.

Дээр дурдсан уул уурхайн салбарын өргөжилт, түүнийг дагасан дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгө оруулалт ихээхэн өсөхөөр байгаатай холбоотой дунд хугацааны эдийн засгийн бодит өсөлт ч харьцангуй өндөр түвшинд байх төлөвтэй байгааг дурьдахад таатай байна.

Монгол Улсын ДНБ-ий хэмжээ 2011 онд 19.4 хувиар, 2012 онд 19.9 хувиар, 2013 онд 14.8 хувиар тус тус өсөх хандлагатай байгаа бөгөөд нэг хүнд ногдох орлогын хэмжээ 2011 онд 3458 ам.доллар, 2012 онд 5234 ам.доллар, 2013 онд

6374 ам.долларт хүрэхээр байна.

Энэхүү өсөлтөнд худалдаа, тээвэр, уул уурхай, боловсруулах болон барилгын салбарын хувь нэмэр өндөр байлаа.

Гадаад худалдааны бараа эргэлт 2011 онд 11 тэрбум ам.доллар, 2012 онд 15.8 тэрбум ам.доллар, 2013 онд 18.7 тэрбум ам.долларт хүрэхээр байна. ДНБ-д эзлэх гадаад худалдааны тэнцлийн алдагдал 2012 онд 1.9 хувь байхаар байгаа бол харин 2013 оноос гадаад худалдааны тэнцэл ашигтай гарч 2013-2014 онд ДНБ-ий 11-13 хувийг эзлэхээр байна. Гадаад худалдаа дунд хугацаанд ашигтай гарах гол нөхцөл нь ашигт малтмалын томоохон ордууд эдийн засгийн эргэлтэд орж байгаатай холбоотойгоор манай улсын экспортын хэмжээ импортынхоос хурдацтай өсөхөөр байгаатай холбоотой юм. Тухайлбал, манай улсын экспортын хэмжээ 2012 онд 23 хувь, 2013 онд 43.4 хувь, 2014 онд 18.4 хувиар тус тус өсөхөөр байгаа бөгөөд импортын хэмжээ энэ хугацаанд тогтвортой 11.2 хувь өсөхөөр байна. Ингэснээр 2013 оноос манай улсын гадаад худалдаа 1,7-2,4 тэрбум ам.долларын ашигтай гарах таатай төлөв ажиглагдаж байна.

Төлбөрийн тэнцэл 2011 онд 1.2 тэрбум ам.долларын ашигтай, 2012 онд 2 тэрбум ам.долларын ашигтай, 2013 онд 2.9 тэрбум ам.долларын ашигтай гарч 2013 оны эцэст гадаад валютын нөөц 8.3 тэрбэм ам.долларт хүрэх төлөвтэй байна.

Эдийн засгийн бодит салбар

Монгол Улсын эдийн засаг нь цөөн хэдэн салбарт тулгуурласан бүтэцтэй, тэдгээр нь боловсруулалтын түвшин бага, анхдагч салбарууд юм. Өөрөөр хэлбэл аж үйлдвэрийн салбарын хөгжил сул байна. Тухайлбал, уул уурхай, хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь 2010 оны байдлаар ДНБ-ий 38 хувийг эзэлж байна. Экспортын бүтцийн 90 хувь нь технологийн агууламжгүй болон нам технологийн бүтээгдэхүүн буюу үндсэндээ түүхий эд байна. Эдгээр бүтээгдэхүүнүүдийн

үнэ дэлхийн зах зээл хамгийн их хэлбэлзэлтэй байдаг. Мөн ДНБ-ий 15 хувийг эзэлж байгаа хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл байгаль цаг уураас хамаарал ихтэй байдаг нь малчид, тариаланчдын амьжиргаанд болоод нийт эдийн засагт байгаль цаг уурын хүндрэл хүчтэй нөлөөлдөг.

Салбаруудаар авч үзэхэд дотор хөдөө аж ахуйн салбарын гол салбар болох мал аж ахуйн салбар дийлэнх нутгийг хамарсан 2009-2010 оны өвлийн зуднаар нийт 10 сая толгой мал хорогдож, тус салбарын нийт үйлдвэрлэл 19 хувиар буурч байсан бол 2011 онд 12 сая толгой төл бойжуулж, салбарын үйлдвэрлэл эхний хагас жилийн байдлаар 14 хувийн өсөлттэй байна.

Засгийн газраас газар тариалангийн салбарт 2008 оноос эхлэн “Атрын аян” хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд үр тариа, төмс, хүнсний ногооны тариалалт үлэмж нэмэгдсэн бөгөөд 2011 онд 343.1 мянган га талбайд тариалалт хийснээс ургац хураалтын урьдчилсан мэдээгээр улаан буудай 419 мянган тонн, төмс 174 мянган тонн, хүнсний ногоо 90.5 мянган тонныг тус тус хураан авах төлөвтэй байна.

Уул уурхайн салбарын үйлдвэрлэл 2011 оны эхний 8 сарын байдлаар бодитоор 8 хувиар өссөн. Үүнд: нүүрсний олборлолтын хэмжээ 28 хувиар, төмрийн хүдрийн олборлолт 2 дахин нэмэгдсэн зэрэг нь голлон нөлөөлөв. Уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн цаашид эрчимтэй нэмэгдүүлэхэд тээвэр, цахилгаан эрчим, ус зэрэг дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгаа юм.

Уул уурхайн салбарт шийдвэрлэх шаардлагатай асуудлын тоонд хариуцлагатай уул уурхайг төлөвшүүлэх, байгаль орчны нөхөн сэргээлтийг сайжруулах, бичил уул уурхай эрхлэгчдийн зохицуулах шаардлагатай байна.

Иймээс ойрын жилүүдэд бүтцийн өөрчлөлтийг хийх томоохон аж үйлдвэрийн төслүүдийг эхлүүлэх, технологи, өндөр технологийг өргөнөөр хөгжүүлэх хөтөлбөрүүдийг

төлөвлөж, томоохон ажлуудын түрүүч нь гэвэл Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор төслийг хэрэгжүүлж эхлэхээр ажиллаж байна. Энэхүү төслийг Монгол Улсад төдийгүй, Зүүн хойд Азийн бүс нутагт хэрэгцээтэй аж үйлдвэрийн цогцолбор болгохоор ажиллаж байгаа бөгөөд БНХАУ, БНСУ, Япон зэрэг хөгжингүй орнуудын аж үйлдвэрийн салбарт хэрэгцээтэй боловсруулсан бүтээгдэхүүнийг нийлүүлж, харилцан ашигтай хамтын ажиллагаа хөгжүүлэх нэг томоохон салбар болно гэдэгт итгэлтэй байна.

Төслийн хүрээнд “Коксын үйлдвэр”, “Хар төмөрлөгийн үйлдвэр”, “Нүүрс хийжүүлэх үйлдвэр”, “Зэс хайлах үйлдвэр”, “Барилгын материалын үйлдвэр”, “Газрын тос боловсруулах үйлдвэр”-үүд, тэдгээрийн найдвартай үйл ажиллагааг хангах дэд бүтэц, инженерийн болон нийгмийн хангамж төлөвлөгдөж байна. Тухайлбал “Коксын үйлдвэр” нь Тавантолгой-Сайншандын төмөр зам ашиглалтад орох үетэй, “Газрын тос боловсруулах үйлдвэр” нь Тавантолгой-Чойбалсангийн төмөр зам баригдахтай цаг хугацаа, үйл ажиллагааны хувьд зохицох бөгөөд ингэснээр бүс нутагт эдгээр бүтээгдэхүүнүүдийг саадгүй тээвэрлэх боломжийг давхар тооцон төлөвлөж байна. Сайншандад боловсруулах аж үйлдвэрийн цогцолбор барьж дэвшилтэт техник, өндөр технологи нэвтрүүлэх төсөл нь Монгол Улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, техник, технологийн хувьд харилцан уялдаатай, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, улмаар Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн хурдцыг нэмэгдүүлэх бөгөөд бүс нутгийн ирээдүйн хөгжлийн хэрэгцээг тодорхой хэмжээгээр хангах төсөл болж чадна гэдэгт итгэлтэй байна.

Дээр дурдсан олон тооны томоохон төслүүдийг хэрэгжүүлэх хөрөнгийг бүрдүүлэхэд нэг эх үүсвэрт түшиглэх боломжгүй, эрсдэл өндөр тул төслийг санхүүжүүлэх хөрөнгийг олон эх үүсвэрээс, үе шаттайгаар бүрдүүлэхээр төлөвлөж байна.

Иймээс ч Монгол Улсын Засгийн газраас төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалтаар барих зарчмыг баримталж байгаа бөгөөд төрийн талаас Засгийн газрын бонд, саяхан шинээр байгуулагдсан Хөгжлийн банкаар дамжуулан санхүүжүүлж, хувийн хэвшлийн дотоодын болон бүс нутгийн хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах эрх зүйн болон эдийн засгийн таатай орчныг бүрдүүлэхээр зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

Үүний нэг жишээ гэвэл Монголын Хөрөнгийн бирж Лондонгийн Хөрөнгийн биржтэй хамтран ажиллахаар болсон явдал бөгөөд бидний зорилгыг стратегийн шинж чанартай болгож байгаа ба энэ нь Монголын хөрөнгийн биржийг олон улсын санхүүгийн зах зээлд гарган таниулах гол хүчин зүйл байх болно.